

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН ГУРВАН ТАЛТ 2017-2018 ОНЫ УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭР

Нэг. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудал

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дараах хуулиудыг шинэчлэн найруулж, нэмэлт, өөрчлөлт оруулахдаа нийгмийн түншлэгч талуудын саналыг тусгана:

- 1.1. Хөдөлмөрийн тухай хууль
- 1.2. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- 1.3. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль
- 1.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- 1.5. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
- 1.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- 1.7. Нийгмийн даатгалын тухай багц хуулиуд

2. Олон Улсын Хөдөлмөрийн дараах конвенциудад нэгдэн орох асуудлыг шийдвэрлүүлнэ:

- 2.1. Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай 167 дугаар конвенц
- 2.2. Аж үйлдвэр, худалдааны хөдөлмөрийн хяналтын тухай 81 дүгээр конвенц
- 2.3. Хөдөө аж ахуйн хөдөлмөрийн хяналтын тухай 129 дүгээр конвенц

3. Олон Улсын Хөдөлмөрийн дараах конвенциудад нэгдэн орох асуудлыг судална:

- 3.1. Нийгмийн хамгааллын тухай 102 дугаар конвенц
- 3.2. Эхчүүдийг хамгаалах тухай 183 дугаар конвенц
- 3.3. Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай 184 дүгээр конвенц
- 3.4. Төрийн албан дахь хөдөлмөрийн харилцааны тухай 151 дүгээр конвенц

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалах асуудал

1. Хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй мэргэжил, ур чадварыг богино хугацаанд олгох хөдөлмөр эрхлэлтийн болон үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулна.

2. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын бүтцийн өөрчлөлтийн улмаас ажлаасаа чөлөөлөгдсөн хүмүүст шинээр мэргэжил олгох, мэргэшүүлэх, ажлын байраар хангах болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгааг хангах чиглэлээр тодорхой төсөл, хөтөлбөрийг тухайн салбарын түншлэгч талууд хамтран боловсруулж хэрэгжүүлнэ.

3. Ажилтнуудын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор компаний хувьцааны тодорхой хувийг ажилтнууддаа эзэмшүүлэх бодлого баримталж, “Ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр” хэрэгжүүлэх боломжийг судална.

4. Бүх төрлийн татварын хэмжээг өөрчлөх, шинэ төрлийн татвар бий болгоход нийгмийн түншлэгч талуудтай урьдчилан зөвшилцөж байна.

5. Валютын ханшны өсөлтөөс шалтгаалан аж ахуйн нэгж, иргэдэд учирч буй хүндрэл бэрхшээл, эдийн засагт үүсч болзошгүй эрсдлийг бууруулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ.

6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зохих хэсгийг ажлын байр бий болгосон болон ажлын байраа хадгалсан аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч, иргэдийг дэмжих зорилтот арга хэмжээнд зарцуулахаар холбогдох хөтөлбөр, дүрэм, журмыг өөрчлөн боловсруулна.

7. Ажил олгогчдод нэн эрэлттэй байгаа 100 хүртэл мэргэжлээр “Ажил мэргэжлийн лавлах”, тэдгээрт суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг ХЭДС-аас санхүүжүүлж, тэдгээрийг МСҮТ-үүдийн сургалтын үйл ажиллагаанд хэрэгжүүлнэ.

8. Зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүдийг нийгмийн түншлэгч талууд хамтран боловсруулна.

9. Малгүй болон цөөн малтай залуу малчдын амьжиргааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хот руу шилжих хөдөлгөөнийг сааруулах зорилгоор Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

10. Ажилгүйдлийг бууруулах Үндэсний хөтөлбөрийг үйлдвэржилт, макро эдийн засгийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

11. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан салбарт шилжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулна.

12. Даатгуулагч тэтгэврийн доод, дээд насны хязгаарын хүрээнд тэтгэвэр тогтоолгох хугацаагаа уян хатан сонгох, ердийн тэтгэврийн наснаас хойш тэтгэвэр тогтоолгох тохиолдолд тэтгэвэр бодох хувь хэмжээг нь нэмэгдүүлдэг байх асуудлыг Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд тусгана.

Гурав. Хөдөлмөрийн харилцааны асуудал

1. Төрийн албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийг боловсронгуй болгох асуудлыг судалж, шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2. Тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх асуудлыг эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн боломжтой уялдуулан 2018 оны улсын төсөв батлагдахаас өмнө талууд нэмэлт хэлэлцээр байгуулж, шийдвэрлүүлнэ.

3. Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын төсвийн хэмнэлт болон өөрийн үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн орлогоос тухайн байгууллагын ажиллагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах асуудлыг хамтын гэрээ, хэлэлцээрээр хэлэлцэн саналыг тусган шийдвэрлэх арга хэмжээ авна.

4. Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмжийн хэмжээг одоогийн хүрсэн түвшингээс бууруулахгүй байх, цаашид мэргэжлээрээ ажиллаж байгаа салбарын нийт ажилтнуудад адил тэгш олгох боломжийг салбарын түвшинд судална.

5. Төрийн албан хаагчдын албан томилолтын ялгааг арилгана.

6. “Хөдөлмөрийн бүтээмжийн хөдөлгөөн”-ийг талууд хамтарч хөгжүүлнэ.

7. Хүн амын өсөлт, газар зүйн байрлалтай уялдуулан төрийн албан хаагчдын бүтэц, тоог зохистой тогтоох асуудлыг судална.

8. Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарыг төрийн албанд хэвээр байлгах, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага, компаниудыг хувьчлахад ажлын байр, нийгмийн хамгааллын асуудлыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

9. Эдийн засгийн хүндрэлтэй холбогдуулан аливаа санхүүгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүн амын цалин орлого, нийгмийн хамгааллын хүрсэн түвшинг дордуулахгүй байх, ажлын байрыг хадгалах улмаар нэмэгдүүлэх нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлнэ.

10. Ипотекийн зээлийн хүрээнд хямд өртөгтэй орон сууц барих хөтөлбөр, төслийг эдийн засаг, санхүүгийн бодлоготой уялдуулан үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

11. Улсын төсвөөр хийж гүйцэтгэсэн гэрээт ажлуудын олгогдоогүй санхүүжилтийг барагдуулна.

12. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний 5 дахь хөтөлбөрийг боловсруулж батлуулна.

13. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудад мэргэжлийн зэрэг олгох журам боловсруулж, мөрдөнө.

14. Бүх шатны боловсролын байгууллагуудын сургалтын хөтөлбөрт эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлыг нэгэн адил хамруулна.

15. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор төсвийн байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг улсын төсөвт тусган хэрэгжүүлнэ.

16. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны болон нийгмийн хариуцлагын стандартыг аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрүүлэхэд

зөвлөх үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах ажлыг талууд хамтран хэрэгжүүлнэ.

Дөрөв. Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх асуудал

1. Үндэсний болон орон нутгийн гурван талт хороо, зөвлөлүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авч, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байна.

2. Монгол Улсын Засгийн газрын “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 370 дугаар тогтоолын хэрэгжилтийг аймаг, нийслэл, яамдын түвшинд танилцаж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж шийдвэрлүүлнэ.

3. “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” Засгийн газраас баримталж буй бодлого, чиглэлийн хүрээнд төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжийг судалж, холбогдох арга хэмжээ авна.

4. Салбарын болон аймаг, нийслэлийн түвшинд байгуулагдсан гурван талт хороо, зөвлөлийн бүрэлдэхүүнд сонгогдсон албан тушаалтан, сонгуультныг чадваржуулах арга хэмжээг зохион байгуулна.

5. Салбар, орон нутгийн хоёр ба гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийн байдалд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын судалгаа, шинжилгээг харгалзан Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос зөвлөмж чиглэл өгч, үр дүнг тооцон ажиллана.

6. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Гомдлын шаардлагын төв болон орон нутгийн зөвлөл, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүрэлдэхүүнд ҮЭ-ийн төлөөллийг тус тус оролцуулна.

7. Хөдөлмөрийн асуудлаар Үндэсний болон аймаг, нийслэл, салбарын чуулганыг гурван тал хамтран зохион байгуулна.

Тав. Хэлэлцээрийг мөрдөх, хэрэгжүүлэх асуудал

1. Энэхүү хэлэлцээр нь талуудын төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

2. Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө шинэ хэлэлцээр байгуулаагүй, эсвэл нэмэлт, өөрчлөлт оруулаагүй бол талууд энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөнө.

3. Хэлэлцээрийн биелэлтэд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо болон хэлэлцээрт оролцогч талууд хамтран хяналт тавина.

4. Улсын хэмжээний хэлэлцээрийн биелэлтийг гурван тал хагас, бүтэн жилээр гаргаж, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороогоор хэлэлцүүлэн олон нийтэд мэдээлнэ.

5. Засгийн газар, ажил олгогч болон үйлдвэрчний эвлэлүүдийн холбоодын удирдлага, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөх, мөн шинэчлэн зохион байгуулагдах нь энэхүү хэлэлцээр дуусгавар болох үндэслэл болохгүй бөгөөд тэдгээрийн залгамжлагчид энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

6. Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг хэлэлцээ хийж шийдвэрлэхэд энэхүү хэлэлцээрийг байгуулахад баримталсан журмыг дагаж мөрдөнө.

7. Энэхүү хэлэлцээрийг биелүүлэх ажлын төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд батална. Хэлэлцээрийн төлөвлөгөөг талуудын болон холбогдох яам, газрын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

8. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад талуудын хооронд үүссэн маргааныг хамтран хэлэлцэх, тохиролцох бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АХЛАГЧ

Н.НОМТОЙБАЯР

САНГИЙН ДЭД САЙД

Х.БУЛГАНТУЯА

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ДЭД САЙД

Ж.САУЛЕ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Д.ОЧИРБАТ

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА


Б.НЯМДАВАА

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН ДАРГА


Л.МӨНХЗУЛ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА


Б.АЛИМАА

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА


Л.ТӨГСБАЯР

**МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОЛБООГ ТӨЛӨӨЛЖ:**

МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ,
ТӨЛӨӨЛӨГЧИЙН АХЛАГЧ


Х.АМГАЛАНБААТАР

МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА


Г.АДЪЯА

МОНГОЛЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ
ДАРГА


М.АЛТАНЦЭЦЭГ

МОНГОЛЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОЛБООНЫ ДАРГА


Ж.БАТЗОРИГ

МОНГОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ
ДАРГА


Б.МЯГМАР

МОНГОЛЫН ТЭЭВЭР ХОЛБОО, ГАЗРЫН
ТОСНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН
ХОЛБООНЫ ДАРГА


Б.РАГЧАА

МОНГОЛЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА

O. Taimuree

О.ГАНТУЯА

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ
УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА

X. Buyanjargal

Х.БУЯНЖАРГАЛ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА

D. Nacagdorj

Д.НАЦАГДОРЖ

МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН ҮЙЛДВЭРЧНИЙ
ЭВЛЭЛИЙН ХОЛБООНЫ ДАРГА

B. Batcogt

Б.БАТЦОГТ

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН
НЭГДСЭН ХОЛБООНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ
БӨГӨӨД ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ,
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН АХЛАГЧ

X. Ganbaatar

Х.ГАНБААТАР

МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ ЭЗДИЙН
НЭГДСЭН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН “ӨЛЗИЙТ ТӨВ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ,
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТЭРГҮҮНИЙ ОРЛОГЧ

N. Dash-Olzii

Н.ДАШ-ӨЛЗИЙ

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА,
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

B. Lkhagvajav

Б. ЛХАГВАЖАВ

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН ҮНДЭСНИЙ
АССОЦИАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Д.ЭНХБОЛД

МОНГОЛЫН БАРИЛГАЧДЫН НЭГДСЭН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

M. Batbaatar

М.БАТБААТАР

МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Т. БЯМБАА

МОНГОЛЫН АРЬС ШИРНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

T. Bayarsaikhan

Т.БАЯРСАЙХАН

МОНГОЛЫН ХҮНСЧДИЙН ХОЛБООНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

X. Gijmaa

Х. ГИЙМАА

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ
АССОЦИАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



Г. ПҮРЭВДОРЖ

МОНГОЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОРШООДЫН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ



С. ЭНХТУЯА

2017 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр